

“ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянхонгор аймаг

2018 он

0

Агуулга	
Аудитын нэр	2
Аудитын код.....	2
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл.....	2
Аудитын зорилт	2
Аудитын хамрах хүрээ	2
Үндсэн мэдээлэл	2
Эрсдэлийн үнэлгээ	3
Аудитын арга зүй.....	3
Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	3
Аудитыг гүйцэтгэх хугацаа.....	4
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	4
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	4
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	4

БАТЛАВ: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Баянхонгор

2018.05.16

Аудитын нэр

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Аудитын код

ҮАГ-БНАТАГ-/2018/-04-ГА

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Монгол улсын ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд :

- Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитыг Баянхонгор аймгийн төвийн Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Баян-Ойт, Соого Сейко зэрэг 6 сургуулийг хамруулан 2016-2017 оны санхүүгийн тайлан тэнцэл, төлөвлөгөө, мэдээ, судалгаа, үдийн цай хөтөлбөрийн холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Үндсэн мэдээлэл

“Тэтгэмж мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр” хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр

тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайд, ЭМС-ийн 2006 оны 379/341 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулиудад “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” батлагдаж, хөтөлбөрийг 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор нэг хүүхдэд олгох үдийн цайны зардлыг өдөрт 600 төгрөгөөр тогтоожээ.

2016 онд “Үдийн цай” хөтөлбөрт аймгийн төвийн ерөнхий боловсролын 6 сургуулийн 1-5 дугаар ангийн 3905 хүүхдийг, 2017 онд 4096 сурагчдыг хамруулахаар тооцон 2016 онд 368.4 сая, 2017 онд 374,3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2016 онд 375,3 сая төгрөг, 2017 онд 373,6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Д.Д	Сургуулийн нэр	2016 он		2017 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Номундалай	84,317.9	84,317.9	81,518.8	81,401.4
2	Номгон	93,213.0	108,925.1	95,700.4	95,700.4
3	Эрдэнэмандал	49367.0	42,916.1	49,895.4	49,792.5
4	Эрдэм	62,670.1	62,588.3	58,199.2	58,192.0
5	Баян-Ойт	44067.0	41,859.7	51,853.2	51,853.2
6	Соого Сейко	34,719.0	34,717.7	37,181.0	36,723.2
	Дүн	368354.0	375,324.8	374,348.0	373,662.7

Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, судалгаанд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. / Эрсдэлийн үнэлгээг хавсралт №01-т үзүүлэв/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Аудитын арга зүйг хавсралт №03-д үзүүлэв/

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг гүйцэтгэх хугацаа

Аудитыг 2018 оны 5-р сарын 07-нд эхэлж, 6-р сарын 11-ний хооронд хийж, үе шатны хяналтаар оруулан хянуулж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Тэргүүлэх аудиторроор баталгаажуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд болон холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. *(Аудитын хөтөлбөрийг хавсралт №04-д үзүүлэв)*

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитын явцыг хянан удирдах ажилтан: Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

Аудит хийх аудитор: Аудитор Б.Азбаяр, аудитор Б.Цэрэнчимэд нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй байхаас гадна холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар бичигдэнэ.

Аудитын тайлангийн төслийг дарга, тэргүүлэх аудиторовын зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн эцсийн хувилбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: 2 хүн *27 өдөр=54 хүн/өдөр.

б. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал 2275,9 мянган төгрөг, бичиг хэрэг 10,0 мянган төгрөг, шатахууны зардал 20,0 мянган төгрөг нийт 2305,9 мянган төгрөг

в. Техник хэрэгсэл: зөөврийн компьютер, принтер, сканнер, диктафон бусад техник хэрэгсэл

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАЖ ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЦЭЦЭГМАА

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



Б.АЗБАЯР

АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД

2018 оны 05 дугаар сарын 09-ны өдөр

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Хавсралт №1

ᠪᠠᠭᠠ ᠳᠤᠨᠳ ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ
ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ
ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ ᠶᠡᠨᠡᠯᠭᠡᠭᠡ

№	Эрсдэл	Магадлал /Их, дунд, бага/	Үр дагавар /Их, дунд, бага/	Үнэлгээ /Их, дунд, бага/
1	Үдийн цай хөтөлбөрийн зардлыг хүүхдийн бодит тоонд үндэслэн төлөвлөөгүй байх	Их	Их	Их
2	Санхүүжилтийг олгохдоо хүүхэд өдрийн бодит гүйцэтгэлээр тооцож олгоогүй байх	Дунд	Дунд	Дунд
3	Зардлын хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан байх	Дунд	Дунд	Дунд
4	Үдийн цай хөтөлбөрийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээний дагуу стандарт шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлээгүй байх	Дунд	Дунд	Дунд
5	Бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд гэрээнд заасан үнээс өндөр үнээр бүтээгдэхүүн нийлүүлсэн байх	Дунд	Дунд	Дунд
6	Бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ нийлүүлэх бүрт лабораторийн шинжилгээний бичиг аваагүй байх	Их	Их	Их
7	Үдийн цай хөтөлбөрт тавих хяналтыг журамд заасан хэмжээнд бүрэн хэрэгжүүлээгүй байх	Их	Их	Их
Ерөнхий үнэлгээ		Дунд	Дунд	Дунд

Их-3, Дунд-4, Ерөнхий дүн-Дунд

АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ



Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн

Үдийн цай хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн үү?

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн ямар байна вэ?

Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулж байна уу?

1.1 Төсвийн шууд захирагч хүүхдийн бодит тоонд үндэслэн тооцсон үдийн цайны төсвийн төслийг ирүүлсэн эсэх

1.2 Санхүү төрийн сангийн хэлтэс үдийн цай хөтөлбөрийн зардлыг ТШЗахирагчийн төслөөр ирүүлсэн хүүхдийн бодит тоонд үндэслэн төлөвлөсөн үү?

2.1 Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөсөний дагуу олгож байна уу?

2.2 Зардлын хэмнэлтийг төрийн санд бүрэн төвлөрүүлсэн үү?

2.3 Үдийн цай хөтөлбөрийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээний дагуу бүтээгдэхүүнээ нийлүүлж байна уу?

2.4 Үдийн цай хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлж байна уу?

3.1 Үдийн цай хөтөлбөрт тавих сургуулийн болон Эцэг эхийн Хяналтын зөвлөлийн хяналт үр дүнтэй хийгдэж байна уу?

3.2 Үдийн цай хөтөлбөрт журамд заасаны дагуу аймгийн ЭМГ, МХГ-ын хяналт үр дүнтэй хийгдэж байна уу?